

# МЭДЭЭЛЭЛ ХАРИЛЦААНЫ ТЕХНОЛОГИЙН ОНОШЗҮЙН СУДАЛГАА, ДГБ-ЫН ДАТА МОДЕЛЬ

2018 оны 12 дугаар сарын 14

Улаанбаатар, Монгол Улс

# МХТ-ийн оношзүйн судалгааны зорилго



Өнөөгийн МХТ-ийн системд үнэлэлт өгөх

Тухайн байгууллага МХТ ашиглан өөрийгөө шинэчлэх чадвартай эсэхийг ойлгож мэдэх

- МХТ гэдэг нь зорилго биш, арга хэрэгсэл юм.

Судлах зүйлс:

- МТ-ийн төлөвлөлт ба МТ-ийн засаглал
- МТ-ийн хөгжүүлэлт ба засвар, техник үйлчилгээ
- Гаалийн байгууллагын МТ-ийн хэрэглээ
- МТ-ийн аюулгүй байдал
- МТ-ийн эрх зүйн орчин
- МТ-ийн дэд бүтэц

# ДГБ-ын 2019 оны уриа

- Худалдаа, Аялал жуулчлал, Тээврийн үйл ажиллагааг саадгүй явуулах УХААЛАГ ХИЛ (SMART Borders): 2018 оны 11 дүгээр сарын 20-ны өдөр тунхагласан

» Гаалийн байгууллага хилийн хяналтын бусад байгууллагатай хамтран худалдаа, аялал жуулчлалыг хөнгөвчлөх, хилийн үйл ажиллагааг хялбарчлах болон стандартчлах, хилийн аюулгүй байдлыг хангахал чухал үүрэг гүйцэтгэдэг

» **S**ecure (Аюулгүй), **M**easurable (Хэмжигдэхүйц), **A**utomated (Автоматжуулсан), **R**isk Management-based (Эрсдэлийн удирдлагад суурилсан), **T**echnology-driven (Технологид хөтлөгдсөн)

» Ухаалгаар ажиллана гэдэг нь шинэ технологийг нэвтрүүлэх явцад бизнес процесстоо ре-инженеринг хийх бэлтгэлтэй байна гэсэн үг



# Дижитал гааль

Дижитал гааль санаачилга нь цаасанд суурилсан гаалийн үйл ажиллагааг цахим үйл ажиллагаагаар орлуулан солихыг эрмэлздэг. Ингэснээр олон улсын хөгжилтэй хөл нийлүүлсэн илүү орчин үеийн түргэн шуурхай гаалийн орчин бүрдэх болсон.

- *Дижитал шийдэл, үйлчилгээг цаашид улам боловсронгуй болгох хүсэл эрмэлзэл*
- *Үйл ажиллагааны гүйцэтгэлийг нэмэгдүүлэхэд дэмжлэх үзүүлэх*
- *Худалдааг илүү хөнгөвчлөх нөхцөл бүрдүүлэх*
- *Big Data буюу их хэмжээний мэдээллийн дүн шинжилгээ, блокчейн, клауд болон хиймэл оюун ухаан зэрэг дэвшилтэт технологийг илүү ихээр нэвтрүүлэх.*

# Дижитал гааль хөгжлийн түвшний загвар



# ДГБ-ын Дата Моделийг яагаад хэрэглэх ёстой вэ?

» Мэдээлэл нь өнөөгийн гаалийн байгууллагын амин судас. Мэдээллийн тусламжтайгаар:
- Эрсдэлийн удирдлага ба онилгоо
- Сонголт, шигшилт
- Дүн шинжилгээ, статистик
- Шийдвэр гаргахад дэмжлэг
- Гүйцэтгэлийн хэмжүүр
- Илүү зайны хяналт
- Түргэвчилсэн бүрдүүлэлт

» S.M.A.R.T хилийн үндсэн бүрэлдэхүүн нь мэдээлэл

» Хил дамнасан олон үйл ажиллагааг явуулах боломжийг мэдээллийн өгөгдөл олгож байдаг:
- Ачаа барааны бүрдүүлэлт, транзит уялдаа холбоо, зорчигчийн хяналт, ОУ-д холбогдсон гааль, Худалдаа эрхлэгч / ИААН, харилцан хүлээн зөвшөөрөх, эрсдэлийн үнэлгээг урьдчилан хийх, цахим худалдаа, нэн даруй эзэнд нь олгох, аюулгүй байдал, аюулгүй хамгааллын менежмент, цахим гэрчилгээ, цахим зөвшөөрөл, цахим үйлчилгээ, рентген төхөөрөмжийн уялдаа холбоо

Гэхдээ…
- Гаалийн байгууллагаас мэдээллийн өгөгдлийг шаардах нь нэмэлт зардал, хүндрэл, нөөцийг худалдаа эрхлэгчээс гаргуулах бөгөөд үүнд цаг хугацаа зарцуулагдаж, сахин биелүүлэхэд хэцүү байдаг;
- Ялангуяа тэдгээр мэдээллийн шаардлага нь:
  - Давхардсан,
  - Төвөгтэй,
  - Өмчлөх эрхийн стандартад суурилсан,
  - Хэт орон нутгийн,
  - Тодорхой тайлбаргүй



# ДГБ-ын Дата Моделийг яагаад хэрэглэх ёстой вэ?

- Хил нэвтрэхтэй холбоотой бизнесийн объектыг стандартчлах, уялдуулах, тодохойлох, тайлбарлах, хялбарчлах, зохион байгуулах, жигдрүүлэх оролдлого юм:

<u>Жишээ:</u>

- **Тээврийн объект:** Нисэх онгоц, усан онгоц, хөлөг онгоц, галт тэрэг, автобус г.м
  - Эдгээр нь бүгд хилийн тээврийн хэрэгсэл *(ДГБ: 15А)*
- **Байгууллага:** Илгээгч, ачуулагч, тээвэрлэгч, экспортлогч, борлуулагч
  - Ачуулагч, илгээгч нь нэг боловч тээвэрлэгчээс ялгаатай.
  - Экспортлогч, ачуулагч болон борлуулагч нь ижил эсхүл өөр хувь хүн / этгээд байж болно.
- **Үнэ:** Барааны үнэ ≠ Гаалийн үнэ
  - Барааны үнэ нь хэлцлийн гэрээ (нэхэмжлэх)-нд тусгагдсан үнэ байх бөгөөд үүнийг татвар хураамжийг бодоход шууд ашиглах боломжгүй. Татвар бодогдох үнийн дүнд (CIF нөхцөлийн хувьд) даатгал болон тээврийн зардлыг харгалзан үзнэ. Бид аль үнийн талаар ярьж байна вэ?
- *Хоёр эсхүл түүнээс дээш хүн хоорондоо ярьж байхдаа нэг ижил зүйлийн талаар яриад байгаа эсхүл өөр, өөр зүйлийн талаар ярьж байгаа эсэхийг мэдэхгүй байгаа үед хүндрэл үүсдэг.*

copyright WCO 2018



# Асуулт / хариулт

- » Гаалийн үйл ажиллагаанд оролцоход шаардагддаг мэдээллийг та гаалийн байгууллагад хэрхэн гаргаж өгдөг вэ; аль арга замаар гаргаж өгөхийг та илүүд үзэх вэ? Яагаад?
- » *(Цаасаар/ Вэбээр / цахим дата дамжуулж / бусад хэлбэрээр)*
- » Тэдгээр бичиг баримтыг гаалийн ямар үйл ажиллагаанд зориулан гаргаж өгдөг вэ?
- » *(Импорт / экспорт / ачааны манифест / транзит / бусад)*
- » Гаалийн системийг ашиглах явцад танд ямар нэг техникийн асуудал гарч байсан уу? Ямар төрлийн асуудалтай тулгарч байсан бэ? Гаалийн байгууллага хэрхэн туслалцаа үзүүлдэг вэ? Хэрхэн асуудлыг шийдвэрлэдэг вэ?
- » *(Үгүй / Бараг үгүй / заримдаа)*
- » *(Цахилгаан эрчим хүч / интернэт эсхүл сүлжээний холболт / програмын алдаа бусад)*
- » Гаалийн үйл ажиллагаатай холбоотой бүх мэдээллийг хялбархан олох боломжтой юу?
- » *(Ном товхимол / мэдээллийн үйлчилгээ / цахим хуудас)*
- » Дараахтай холбоотой үзэл бодлоо хуваалцана уу:
  - Гаалийн өнөөгийн ашиглаж буй МХТ-ийн систем болон цахим үйлчилгээ,
  - Систем болон цахим үйлчилгээг ашиглахад гардаг хүндрэлүүд,
  - Одоогийн байдлаар цаасанд суурилсан, гар аргаар хийгдэж буй, цаашид цахимжуулах шаардлагатай үйлчилгээ, үйл ажиллагааны талаар
  - Тэдгээрийг хэрхэн сайжруулж болох вэ?



# Анхаарал тавьсанд баярлалаа

tejo.kusuma@wcoomd.org
Техникийн ажилтан